

**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2023 ОНЫ 06 ДУГААР САРД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

Агуулга: БНСУ дахь Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Үйлчилгээний төв нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг, Нийгмийн даатгалын тасаг гэсэн 2 тасагтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд ажлын чиг үүрэг, хуваарийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. *Дотоод ажлын хүрээнд.*
2. *Хөдөлмөрийн гадаад харилцааны ажлын хүрээнд.*
3. *Судалгаа, мэдээллийн ажлын хүрээнд*
4. *Сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд*
5. *Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой өргөдөл, гомдлын хүрээнд.*
6. *БНСУ-д хууль бусаар ажиллаж байгаа иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын хүрээнд*
7. *Гэрээт ажилчдын ахисан түвшний боловсролыг дэмжих ажлын хүрээнд.*
8. *БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох*
9. *БНСУ-д оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох*
10. *Нийгмийн даатгалын сангийн орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд*
11. *БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр (Е-9, Е-8, Н-2 визээр) ажиллах хугацаандаа тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг олгуулах ажлын хүрээнд*
12. *Төрийн үйлчилгээний нэгдсэн цахим систем ашиглан үзүүлсэн үйлчилгээний хүрээнд*

Тайлангийн хугацаанд тус ХНХҮТ нь Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд Монгол Улс, БНСУ-ын Хөдөлмөрийн Яам хоорондын “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо”-ны дагуу БНСУ-д ажиллах хүч илгээх тухай харилцан ойлголцлын санамж бичиг, ХНХЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд ажил олгогч, ажилтан хоёрын хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээнд хяналт тавьж биелэлтийг хангуулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Монгол Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг, бусад холбогдох хууль тогтоомжууд болон “Сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 тоот албан даалгаврыг тус тус хэрэгжүүлэн, БНСУ-д ажиллаж амьдарч буй иргэдийнхээ эрх ашгийг хамгаалахаар ажиллаж байна.

БНСУ-д 2023 оны 06 дугаар сард хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 143 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулав. Сургалтад 06 дугаар сарын 07-ны өдөр 48 иргэн, 06 дугаар сарын 28-ны өдөр 95 иргэн тус тус хамрагдав.

1. Дотоод ажлын хүрээнд:

- Ёжү олон улсын сургалтын төвд хандан Монгол улсаас шинээр ирэх гэрээт ажилчдад зориулсан сургалтыг тус төвд биечлэн очиж танхимаар заах хүсэлтийг 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр илгээв.
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 тоот “Шил ажиллагааг эрчимжүүлэх тухай” албан даалгавраар өгөгдсөн “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийг ил тод болгох чиглэлээр <https://seoulcenter.mlsp.gov.mn/> цахим хуудасны санхүүгийн ил тод байдлын хэсгийг шинэчилж, тасаг тус бүрийн идэвхтэй ажиллаж буй шилэн дансны холбоосыг байршуулав.
- <https://seoulcenter.mlsp.gov.mn/> цахим хуудасны хууль эрх зүйн хэсгийг шинэчилж 24 бүлэг эрх зүйн актыг нийтлэв.
- Байгууллагын 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.
- Нийгмийн даатгалын аппликейшнд бүртгүүлэх 2 иргэний хүсэлтийг хүлээн авч, бүртгэлийг баталгаажуулан, иргэдэд бүртгүүлэх кодыг илгээв. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол нөхцлийг хангасан, нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх үүссэн 4 даатгуулагчид зохих журмын дагуу даатгуулагчийн тодорхойлолтыг гаргаж, шаардлагатай бичиг баримтыг монгол хэл рүү хөрвүүлж өгөв. Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогыг НДЕГ-ын Төрийн банкин дахь холбогдох дансанд шилжүүлэн, тайлан мэдээг гаргаж НДЕГ-ын СБГ-ын холбогдох албан тушаалтанд хүргүүлэв. Мөн 6 даатгуулагчаас ирсэн өргөдлийг хүлээн авч, цаг тухайд нь шийдвэрлэв.
- 6 дугаар сарын 8, 15, 23-ны пүрэв гаригуудад ТАЗ-өөс төрийн албан хаагчдын дунд уламжлал болгон зохион байгуулж буй “7:4:10” сургалтад тасгийн мэргэжилтнүүд хамрагдав.
- Сөүлийн Жүнбүгийн цагдаагийн газартай хамтран гадаад иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээлэл хүргэв.

2. Гадаад харилцааны ажлын хүрээнд.

- 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр БНСУ-ын Гуан-яа хууль зүйн төвтэй харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтран ажиллах зорилгоор талууд харилцан зөвшилцөж санамж бичиг байгуулав. Үүнд: ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
 - “Гуан-яа хууль зүйн төв” нь БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд хууль эрх зүйн туслалцаа үзүүлэн ажиллана. Үүнд: (БНСУ-д ажиллаж амьдарч буй Монгол улсын иргэд, хөдөлмөрийн гэрээт ажилчид, тус төвийн мэргэжилтнүүд хамрагдах)
 - БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь “Гуан-яа хууль зүйн төв” болох Солонгос дахь Гадаад иргэдийн хууль зүйн туслалцааны төв (Korea Foreigner Legal Support Center /www.imavictim.or.kr)- ийн үйл ажиллагааг олон нийтэд таниулж сурталчлан ажиллана.
- Төвийн дарга Гадаад иргэдийн хүний эрхийг хамгаалах төвийн дарга Сог Вон Жинтэй Монгол иргэдэд тусламж, дэмжлэг олгуулах талаар албан уулзалт хийв.

3. Мэдээлэл, судалгааны ажлын хүрээнд

- Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 тоот “Шил ажиллагааг эрчимжүүлэх тухай” албан даалгавраар өгөгдсөн “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийг ил тод болгох чиглэлд хяналт үнэлгээ хийв.
- Байгууллагын эрсдлийн түвшнийг үнэлэх судалгааг нийт ажилтнуудаас авч, мэдээллийг ангилан, дүгнэлт гаргав.

4. Сургалт, сурталчилгаа, судалгааны ажлын хүрээнд:

- БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр шинээр ирэх 143 иргэнд ирэхийн өмнөх 2 цагийн сургалтыг 06 дугаар сарын 07, 28 -ны өдрүүдэд хийж гүйцэтгэв. Иргэдэд:
 1. ХНХҮТ-ийн үйл ажиллагааны товч танилцуулга
 2. Солонгос улсын хууль, дүрэм, журам
 3. Монгол иргэдийн гэмт хэрэгт холбогдож буй байдал
 4. Үйлдвэрийн осол, үйлдвэрийн ослын даатгал, ХАБЭ, ослоос урьдчилан сэргийлэх
 5. Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
 6. Ур чадвартай ажиллах хүч E7 визний талаар
 7. Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу талуудын талаар
 8. Нийгмийн даатгал гэсэн сэдвээр гэрээт иргэдэд мэдээлэл, зөвлөгөөг өгч асуусан асуултад хариулав.
- БНСУ-ын Хууль зүйн яамнаас ард иргэдийн аюулгүй байдалд заналхийлж буй хар тамхины хэрэгтэй холбоотойгоор үйлдэгдэж байгаа гадаад иргэдийн гэмт үйлдэл, хууль бусаар оршин суугаа иргэдийг ажилд зуучлах үйл ажиллагаа явуулдаг брокерын үйлдэл зэргийг таслан зогсоох зорилгоор Хууль зүйн яам, Цагдаагийн газар, Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Зам тээврийн яам, Далайн эргийн хамгаалалтын цагдаагийн хэлтэс гэх зэрэг яам, тамгын газрууд хамтран 2023 оны 06 сарын 12 ~ 07 сарын 31 хүртэл 50 хоногийн турш үргэлжлэх хууль бус оршин суугчдыг илрүүлэх шалгалт явуулж албадан нутаг буцаахтай холбоотой мэдээлэл орчуулан 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр төвийн цахим хуудсанд түгээв.
- Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 917, үүнээс 896 иргэн, даатгуулагч, ажил олгогчид утсаар, 21 иргэн, даатгуулагчид биечлэн Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад төрлийн мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч, сурталчилгааны материал тараан ажиллав.

5. Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой өргөдөл, гомдол:

- ХНХТ нь 2023 оны 06 дугаар сарын 01-нээс 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд иргэд байгууллагаас хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдүүлэхээр танхим, факс, цахим болон утсаар нийт 305 иргэний санал, хүсэлт, өргөдөл гомдол ирсний дагуу БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Үндэсний тэтгэврийн албатай болон ажил олгогч болон холбогдох бусад байгууллагуудтай харилцаж, харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрхзүйн зөвлөгөө өгч ажиллав. Гэрээт ажилчидтай холбоотой БНСУ-ын “Самсунг” даатгалын газраас оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, нутаг буцах зардлын даатгал олгуулах, гэрээт

болон хууль бусаар ажиллаж буй иргэдийн гэнэтийн ослын даатгал, үйлдвэрийн ослын даатгалын зэрэг нийт 81,340,373 воныг иргэдэд олгуулж ажиллав. Үүнд: Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү 16,172,303 вон, нутаг буцах замын зардал 2,970,000 вон, Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалинд 50,008,070 вон, хууль бусаар ажилладаг иргэдийн авч чадаагүй цалин хөлс 10,940,000 вон холбогдох байгууллагуудаас гаргуулав.

- Төвийн цахим хуудсаар ирж буй өргөдлийг төрөлжүүлэн хүлээн авч, 19 иргэдийн санал, хүсэлтэд холбогдох зөвлөгөө мэдээлэл өгөв.

6. БНСУ-д хууль бусаар ажиллаж байгаа иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын тухайд:

- Т.С нь аяллын визээр орж ирэн ажиллаж байгаад сүүлийн сарын цалингаа авч чадаагүй байсныг ажил олгогчтой холбогдон нэхэмжилж 1,300,000 воныг олгуулав.
- Хууль бусаар хөдөлмөр эрхэлж буй О.Б нь ажлын байран дээрээ үйлдвэрлэлийн осолд орсон тул эмчлүүлж буй эмнэлгийн Хөдөлмөр халамжийн корпорацийн харьяа үйлдвэрлэлийн ослын даатгалын байцаагчид хандан эмчилгээний төлбөр олгуулах өргөдөл боловсруулан илгээж зөвшөөрсөн хариу хүлээн авав.

7. Ахисан түвшнийг дэмжих ажлын хүрээнд

- Хоёр улсын Хууль зүйн яамнаас БНСУ-д хууль бусаар оршин сууж буй монгол иргэдийн тоог бууруулах Засгийн Газрын хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд E-9 визээс E-7-4 виз рүү хувирган амжилттай ажиллаж байгаа гэрээт ажилтан Есболатын үйлдвэрт Eagle телевиз сурвалжлагын багтай хамт очиж яриа авч цуврал контент бэлтгэв.

8. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох ажлын хүрээнд

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд 55 иргэнийг шинээр хамруулан <https://app.ndaatgal.mn:811/ndweb> програмд мэдээллийг бүртгэн гэрээ байгуулав. Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэдэд шинээр 55, гэрээний хугацаа сунгасан 28, ажлын байраа сольсон, гэрчилгээг гээж үрэгдүүлсэн, албан байгууллага нь хүсэлт гаргасан 6 даатгуулагчид Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг тус тус бичиж олгов.

9. БНСУ-д оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох

НДЕГ-ын даргын 2021 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн А/35 тоот тушаалын дагуу “Журам шинэчлэн батлах тухай” журмын дагуу тус улсад оршин сууж буй монгол иргэдийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд иргэдийг хамруулж байна.

06 дугаар сарын 30-ны байдлаар сайн дурын даатгалд нийт 931 даатгуулагчийн бүртгэл хийгдэж, холбогдох хувийн хэргийг хөтлөн <https://app.ndaatgal.mn:811/sdkorea/> програмд мэдээллийг тогтмол шинэчлэн, хяналт тавин ажиллав.

Тайлант хугацаанд 18 иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулж, гэрээ байгуулав. БНСУ-ын ААН-д хөдөлмөр эрхэлдэг 27 даатгуулагчийн хүсэлтийн дагуу Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг бичиж олгов. Мөн 2023 оны 06 дугаар сарын 30-наар гэрээ дуусгавар болсон даатгуулагч нарын гэрээг сунгаж ажиллав.

10. Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд.

НДЕГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 тушаалаар тус тасгийн 2023 оны орлогын төлөвлөгөө 3,347,614,600.00 төгрөгөөр батлагдсан бөгөөд сар бүрийн орлогын төлөвлөгөө 278,967,883.33 төгрөг болно.

Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл 42,495,820.00 вон, сайн дурын даатгалын шимтгэл 43,835,807.00 вон, нийт 86,331,627.00 вон буюу 227,915,495.28 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, 06 дугаар сарын орлогын төлөвлөгөөг 82 хувийн гүйцэтгэлтэй биелүүлэв. Тэтгэврийн даатгалын буюу <https://app.ndaatgal.mn:811/ndweb/> програм, сайн дурын даатгалын буюу <https://app.ndaatgal.mn:811/sdkorea> програмд даатгуулагчдын мэдээлэл, гэрээний хугацаа, шимтгэл төлөлтийн тооцоог хянан, төлөлт хийлгэж ажиллав.

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын ажил олгогчдод тухайн сарын болон өмнөх саруудын шимтгэл төлөхийг сануулж, 439 ширхэг нэхэмжлэл факсаар илгээн, 623 даатгуулагчтай шимтгэл төлөхийг шаардаж утсаар холбогдов.

Орлогын төлөвлөгөөний биелэлт 06 дугаар сарын байдлаар харуулбал

Хүснэгт-1

/2023.06.30-ны байдлаар, ханш 2.64/

Сар	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого		Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь	Тухайн сарын МБ-ны эхний даваа гаригийн хаалтын ханш
		Воноор	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр		
6	278,967,883.33	42,495,820.00	112,188,964.80	43,835,807.00	115,726,530.48	86,331,627.00	227,915,495.28	82	2.64

11. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр (Е-9, Е-8, Н-2 визээр) ажиллах хугацаандаа тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг олгуулах ажлын хүрээнд

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар НДЕГ-аар дамжуулан тус тасагт ирүүлсэн 188 дугаар ээлжийн 2, 189 дүгээр ээлжийн 3 иргэний материалыг тус тус хүлээн авч, БНСУ-ын УТА-д хүргүүлсэн. Өмнө нь ирүүлсэн 183, 185, 186, 187 дугаар ээлжийн хариуг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

12. Төрийн үйлчилгээний нэгдсэн цахим систем ашиглан үзүүлсэн үйлчилгээний хүрээнд

- ХУРДАН төрийн цахим үйлчилгээний системийн операторын горимоор 26 үйлчилгээ, киоск машинаар 3 лавлагааг иргэдэд хүргэж ажиллав.

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАСГИЙН
САР ТУТМЫН ТООН МЭДЭЭ
/2023 оны 06 дугаар сар/**

№	Агуулга	Дүн
1	Иргэдэд олгуулсан мөнгөн дүн	81,340,373 вон
2	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол	305